

ТӨРИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

EVALUATION OF THE DEVELOPMENT PROGRAM OF SPECIAL STATE ORGANIZATIONS AND ITS IMPLEMENTATION.

А.Оюунболд

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн гуравдугаар хэлтсийн
шууданч, цагдаагийн дэд ахлагч

Н.Номин-Эрдэнэ

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн гуравдугаар хэлтсийн
бичиг хэргийн эрхлэгч, архивч, цагдаагийн дэд ахлагч

ХУРААНГУЙ:

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын гуравдугаар хэлтэс нь 2020 оноос 2024 онд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг хангах чиг үүргээ ажилттай хэрэгжүүлнэ ажилласан байна.

2020 оны Сонгинохайрхан дүүргийн гуравдугаар хэлтэс нь 2020 онд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын үр дүнг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, албаны сургалт, соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах, алба хаагчдын ажлын бүтээлч чанар, үр дүнг дээшлүүлэх зорилт тавин ажилласан. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхээр 5 зорилт, 39 заалт бүхий төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажилласан.

2024 оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, дүүргийн цагдаагийн газрын энэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Сонгинохайрхан дүүргийн гуравдугаар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт 46 ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт, үр дүн 86,9 хувьтай байна.

Түлхүүр үг: Алсын хараа-2050, гэмт хэрэг, зөрчил, цагдаагийн байгууллага, техник технологи

Үндсэн хэсэг

Манай улсад сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хөдөлгөөн, тархалт, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын дагуу тодорхойлж, цаашдын чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэхэд жилд дунджаар 31 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 184.8 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч, 981 хүн нас барж, 10351 хүн бие махбодоороо гэмтэж, эрүүл мэндээрээ хохирсон ба нийт гэмт хэргийн илрүүлэлтийг шинэчлэн баталсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанд буюу сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 2017 онд 35.6, 2018 онд 36.0, 2019 онд 44.9 хувьтай байна¹.

Дээрх тоо баримтаас дүгнэхэд манай улсад 5 жилийн дараа буюу 2024 онд гэмт хэрэг 41515 буюу 14.6, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 1135 буюу 21.5 хувиар, зам тээврийн осол 2.9 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30.0, гэмт хэргийн улмаас нас баралт 10.0, бусдын бие махбодод гэмтэл учруулах зөрчил 15.0 хувиар тус тус өсөх хандлагатай гэсэн төсөөлөл гарч байна².

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн, аргачлалын дагуу тооцоолоход 2018 оны байдлаар жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 10.000 хүнд 169 гэмт хэрэг, дэлхийн улс орнуудын 100.000 хүн тутамд харьцуулан тооцоолох аргаар тооцоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 100.000 хүнд 1686 гэмт хэрэг тус тус ногдож байгаа нь хүн ам багатай манай улсын хувьд гэмт хэргийн гаралт өндөр байгааг харуулж байна³.

Уг төсөл нь 2020-2024 оны хооронд хэрэгжиж байгаа бөгөөд төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино⁴.

Нэг. ТӨРИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ БА ҮР ДҮН

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь үр дүнд суурилсан нэгдсэн

¹ Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт


² Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт

³ Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт

⁴ Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт


удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд одоо, өнгөрсөнд дүн шинжилгээ хийж, ирээдүйг төлөвлөх үйл явц юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсын хөгжлийг урт, дунд, богино хугацаанд хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичгийн хүрээнд тодорхойлохоор хуульчилсан. Энэ нь эхлээд бодлогоо тодорхойлох, түүнийг нарийвчлан төлөвлөх гэсэн дараалалтай үйл ажиллагаа хийгдэхийг харуулж байна.

Төрийн бодлогыг бүрэн танин мэдэхийн тулд төрийн бодлогын үйл явцын логик холбоог ойлгох нь чухал. Төрийн бодлогын хүрээнд бодлогын орц, үйл ажиллагаа, гарц, бодлогын зорилго, зорилт буюу бодлогын үр дагавар, үр нөлөө хэмээх ойлголтууд хөндөгддөг. Бодлогын үр дагавар, үр нөлөөг бүхэлд нь бодлогын үр дүн хэмээн тодорхойлж байна. Төрийн бодлогыг үйл явц талаас нь авч үзвэл тодорхой орцыг татан төвлөрүүлж, хуваарилсны үндсэн дээр төрийн холбогдох байгууллага, албан хаагчид үйл ажиллагаа хэрэгжүүлж, үйл ажиллагааны эцэст холбогдох талуудад гарц буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж, тэрхүү бүтээгдэхүүн, үйлчилгээний шууд болон дам нөлөөгөөр үр дүн бий болгохыг зорьж буй зорилтот үйл ажиллагаа юм.



хэмээн тодорхойлж болох юм. Эндээс авч үзвэл бодлогын үр дүн гэдэг нь ард түмний амьдралын чанар, аюулгүй байдал, иргэдийн нийтлэг эрх ашиг, улс орны хөгжил, нийгмийн харилцаанд гарах өөрчлөлт юм.

Зураг 1. Төрийн бодлогын үйл явц



Дээрх зураглалд дурдагдсан ойлголтыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:¹

Орц - Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах цаг хугацааны, хүний, санхүүгийн, материалын (мөнгөн бус) болон институцийн чадамж (технологийн болон мэдээллийн гэх мэт)

Үйл ажиллагаа - Орцыг ашиглан бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас хэрэгжүүлж буй багц арга хэмжээ, ажил


Гарц – Бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны эцэст холбогдох талуудад нийлүүлж байгаа эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

Үр дагавар - Гарцаас шууд хамаарч бий болох өөрчлөлт

Үр нөлөө - Гарцаас дам, үр дагавраас шууд хамааралтайгаар бий болох өөрчлөлт

Төрд олгогдсон эрх, үүрэг болон бодлогын үйл явц нь үр дүнг удирдах, түүнд нөлөөлөх боломжийг олгодог. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд орц, үйл ажиллагаа, гарц, үр дүнг логик уялдаатай төлөвлөдөг.

Зураг 2. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хамрах хүрээ²




Монгол Улсын төрийн бодлого, удирдлагын эрх зүйн өнөөгийн орчны хүрээнд үр дүнг төлөвлөх үйл явцын эцэст гарах бүтээгдэхүүнийг /баримт бичиг/ дараах зураглалаар илэрхийлж болно.

¹ Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт гарын авлага-2024

² Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт гарын авлага-2024

Зураг 3. Төрийн бодлого, удирдлагын хүрээн дэх төлөвлөлтийн уялдааны зураглал 1



Хөгжлийн бодлогын баримт бичиг:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /30 жил/
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр /10 жил/

Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг:

- Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /5 жил, үндэсний түвшин/
- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /5 жил, орон нутгийн түвшин/
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр / 4 жил, үндэсний түвшин/
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /4 жил, орон нутгийн түвшин/
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв /1 жил/

**ХОЁР. “АЛСЫН ХАРАА-2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ГУРАВДУГААР
ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨРТ УЯЛДАА ХОЛБОО**

Жилд дунджаар 31.000 гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, иргэд аж ахуйн нэгжид 184.8 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч 900 гаруй хүн нас барж, 10351 хүн эрүүл мэндээрээ хохирчээ. Эдгээр асуудлыг цагдаагийн байгууллага 90 гаруй хуулийн 180 орчим хэм хэмжээний хэрэгжилтийн хүрээнд иргэд олон нийтэд хууль сахиулах үүргийг гүйцэтгэн ажиллаж байгаа ч дээрх тоон үзүүлэлтүүд өсөх хандлага ажиглагдсаар байгаа аж. Цаашид хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахад техник технологийн хувьд хоцрогдсон, үйл ажиллагааны арга боловсронгуй болоогүй, алба хаагчдын ажлын ачаалал их, төсөв хөрөнгийн хүрэлцээ дутмаг зэргээс шаардлагын түвшинд хүрч ажиллаж чадахгүй байна хэмээн үзэж байгаа юм.

¹ Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт гарын авлага-2024

Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Энэ зорилгын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын гуравдугаар хэлтэс нь:

- Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлнэ.
- Цагдаагийн албаны бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг сайжруулна.
- Үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлнэ.
- Өндөр технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангана.
- Иргэдийн оролцоо, бүх талын хамтын ажиллагааг дэмжинэ.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 5 зорилт, 46 ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Хөтөлбөр хэрэгжсэнээр цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх сайжирч, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшилж, үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлэн, Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн гудамж, зам, талбайг камержуулах, хүн хүчийг хэмнэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, аюулгүйн бүсүүдийг бий болгох, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд бодит ахиц, үр дүн гарган ажиллаж Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын гуравдугаар хэлтсийн нийт 12 хороог аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтарч камержуулж байна.

Дүгнэлт

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд ахиц гарч, гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, шинэ мэдлэг, дэвшилтэт техник, технологи нэвтэрсэн, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бэхжин, алба хаагчийн хууль зүй, эдийн засаг, нийгмийн баталгаа сайжирч, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль сахиулах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлын баталгааг хангахад суурилж байна.